



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

ТОГТООЛД ХАВСРАЛТ НЭМЭХ, ТОГТООЛЫН ХАВСРАЛТ ӨӨРЧЛӨН БАТЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 10.4, 20.1, Төрийн албаны зөвлөлийн саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

- 1."Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолд энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт" гэсэн 7 дугаар хавсралт нэмсүгэй.
- 2.Мөн тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ийг 2 дугаар хавсралтаар, 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ийг 3 дугаар хавсралтаар тус тус өөрчлөн баталсугай.
- 3.Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан төрийн архивын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт нь төрийн захиргааны болон шүүх, прокурор, гадаад харилцаа, батлан хамгаалах, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, улсын хил хамгаалах байгууллагын бүтцэд ажилладаг төрийн жинхэнэ албан хаагчдад хамаарахгүй.
- 4.Энэ тогтоолыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД Х.БУЛГАНТУЯА

Засгийн газрын 2024 оны 02 дугаар
сарын 28-ны өдрийн 84 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт
Засгийн газрын 2023 оны 06дугаар
сарын 21-ний өдрийн 240 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ, ТҮҮНД ХАМААРАХ АЛБАН ТУШААЛЫН
ЖАГСААЛТ

№	Зэрэглэл	Албан тушаал			"Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08"-д заасан индекс/код	Дүйцүүлэх албан тушаал
		Удирдах	Гүйцэтгэх	Туслах		
		1	2	3		
1.	ТҮБД-5	1.Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын захирал			1345-01-1345-07,	1.Төрөлжсөн асрамж, халамжийн цэцэрлэгийн эрхлэгч
2.	ТҮБД-4	1.Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын сургалтын менежер	1.Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч		2351-03-2351-07, 2351-01, 2351-02, 2635-22, 2635-35, 2634-12, 2352-35, 2342-01-2342-04, 2342-06-2342-08	1.Төрөлжсөн асрамж, халамжийн байгууллага, байнгын ажиллагаатай хүүхдийн зуслангийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч 2.Төрөлжсөн асрамж, халамжийн цэцэрлэгийн багш 3.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах тусгай хэрэгцээт боловсролын багш 4.Насан туршийн суралцахуйн төвийн сургалтын менежер
3.	ТҮБД-3		1.Ерөнхий боловсролын сургуулийн бага боловсрол олгох багш 2.Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн багш		2341-01, 2341-02, 2330-01-2330-30, 2310-92, 2330, 2341-02	1.Албан бус боловсролын багш
4.	ТҮБД-2		1.Дотуур байрны багш		2359-01, 2352-34	
5.	ТҮБД-1			1.Багшийн туслах	2342-05, 2352-33,	1.Төрөлжсөн асрамж, халамжийн сургууль, цэцэрлэгийн багшийн туслах

Засгийн газрын 2024 оны 02 дугаар
сарын 28-ны өдрийн 84 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт
Засгийн газрын 2023 оны 06 дугаар
сарын 21-ний өдрийн 240 дүгээр
тогтоолын 6 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ, ТҮҮНД ХАМААРАХ АЛБАН
ТУШААЛЫН ЖАГСААЛТ

№	Зэрэглэл	Албан тушаал		
		Удирдах	Гүйцэтгэх	Туслах
		1	2	3
1.	ТҮ-12	1.Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын дарга		
2.	ТҮ-11	1.Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын нэгжийн дарга 2.Засгийн газрын агентлаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын дарга	1.Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяаллын сургуулийн сургалтын профессор	
3.	ТҮ-10	1.Засгийн газрын агентлаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын нэгжийн дарга	1.Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяаллын сургуулийн сургалтын дэд профессор	
4.	ТҮ-9	1.Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын ерөнхий инженер, урьдчилан сэргийлэхийн технологич инженер 2.Орон нутгийн амралт, хүүхэд, залуучуудын зэрэг төсвийн байгууллагын дарга	1.Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяаллын сургуулийн сургалтын ахлах багш	
5.	ТҮ-8		1.Эдийн засагч 2.Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын ахлах мэргэжилтэн, инженер 3.Засгийн газрын агентлаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын ерөнхий инженер, ерөнхий технологич 4.Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяаллын сургуулийн сургалтын багш 5.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын менежер 6.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний төвийн менежер	

6.	ТҮ-7		<p>1.Маркетинг, олон нийттэй харилцах ажилтан, хүний нөөцийн ажилтан</p> <p>2.Программист, сүлжээний инженер, хуулийн зөвлөх, архитектурч, технологич</p> <p>3.Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын мэргэжилтэн</p> <p>4.Засгийн газрын агентлаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын ахлах мэргэжилтэн, инженер, ахлах техникч</p> <p>5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан</p>	
7.	ТҮ-6		<p>1.Нийгмийн ажилтан, их эмч, орчуулагч, инженер, биологич, агрономич, химич, физикч, сэтгэл зүйч</p> <p>2.Яамны эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын зохион байгуулагч</p> <p>3.Засгийн газрын агентлаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын мэргэжилтэн, техникч, ажилтан</p> <p>4.Улсын тусгай хамгаалалттай газрын Хамгаалалтын захиргааны туслах байгаль хамгаалагч</p>	
8.	ТҮ-5		<p>1.Механикч, техникч, бага эмч</p> <p>2.Засгийн газрын агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд ажилладаг төрийн үйлчилгээний төсвийн байгууллагын зохион байгуулагч</p>	
9.	ТҮ-4		<p>1.Нарийн бичгийн дарга, диспетчер, нярав, сувилагч</p>	
10.	ТҮ-3		<p>1.Жолооч, цахилгаанчин, слесарь, токарьчин, зураач, гэрэл зурагчин, харуулын ахлагч, кабельчин, лаборант, холбоочин</p>	
11.	ТҮ-2		<p>1.Хуулагч, олшруулагч, тоо бүртгэгч, данс хөтлөгч, экспедиторч, операторч, мужаан, бичээч, оёдолчин, үсчин, шил үлээгч, тасалбар түгээврийн кассчин, өртөөч, уурын зуухны галч, тогооч, анчин, хор өгөөш найруулагч, ариутгах төхөөрөмжийн аппаратчин, асрагч</p>	
12.	ТҮ-1		<p>1.Жижүүр, хаалгач, манаач, сахиул, харуул, зөөгч, түгээгч, үйлчлэгч, цэвэрлэгч, зарлага, хувцас өлгөгч, галч, билет шалгагч, ачигч, угаагч, индүүдэгч, хатаагч, амьтан маллагч, хувцас хадгалагч, ариутгагч, шатаах зуухны ажилчин, лифтчин, худгийн моторчин</p>	<p>1.Гал тогооны туслагч, туслах малчин</p>

Засгийн газрын 2024 оны 02 дугаар
сарын 28-ны өдрийн 84 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт
Засгийн газрын 2023 оны 06дугаар
сарын 21-ний өдрийн 240 дүгээр
тогтоолын 7 дугаар хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН БУСАД БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ,
ТҮҮНД ХАМААРАХ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

№	Зэрэглэл	Албан тушаал		
		Удирдах	Гүйцэтгэх	Туслах
1	2	3	4	
1.	ТҮМ-10	1.Үндэсний төв архивын захирал		
2.	ТҮМ-9	1.Төрийн архивын дарга 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн захирал 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн захирал 4.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн захирал 5.Нислэгийн цаг уурын төвийн дарга		
3.	ТҮМ-8	1.Үндэсний төв архивын нэгжийн дарга, салбар архивын дарга 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн чанар, техникийн менежер, нийслэлийн лабораторийн дарга 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн ерөнхий эмч		
4.	ТҮМ-7	1.Төрийн архив, салбар архивын нэгжийн дарга 2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн эрхлэгч, нэгжийн дарга 3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн эрхлэгч, нэгжийн дарга 4.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн нэгжийн дарга 5.Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн нэгжийн дарга 6.Нислэгийн цаг уурын төвийн нэгжийн дарга	1.Цаг уур, орчны шинжилгээний газрын ерөнхий инженер, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер 2.Нислэгийн цаг уурын төвийн аюулгүй байдал, чанарын хяналтын ахлах мэргэжилтэн 3.Ерөнхий нягтлан бодогч	

5.	ТУМ-6		<p>1.Төрийн архивын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, ахлах зааварлагч-арга зүйч, ахлах архивч, ахлах сэлбэн засагч, ахлах архивч-операторч, хадгалалт хамгаалалтын технологич, мэдээллийн технологийн ажилтан</p> <p>2.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ахлах шинжээч</p> <p>3.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн ахлах шинжээч, судлагч</p> <p>4.Цаг уур, орчны шинжилгээний газрын инженер</p> <p>5.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн байгаль орчны ахлах шинжээч, ахлах мэргэжилтэн</p> <p>6.Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн ерөнхий инженер, ахлах мэргэжилтэн</p> <p>7.Нислэгийн цаг уурын төвийн ерөнхий инженер, урьдчилан мэдээлэхийн ерөнхий технологич инженер, ахлах мэргэжилтэн</p> <p>8. Нийслэлийн лабораторийн ахлах шинжээч</p> <p>9. Аймаг, орон нутгийн лабораторийн эрхлэгч, чанарын менежер, 10.Аймаг, нийслэлийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн урьдчилан мэдээлэхийн технологич инженер</p>	
6.	ТУМ-5		<p>1.Төрийн архивын эрдэм шинжилгээний ажилтан, зааварлагч-арга зүйч, архивч, кино дүрс бичлэгийн инженер, сэлбэн засагч, зохион байгуулагч</p> <p>2.Төрөлжсөн болон тусгай архивын ахлах зааварлагч-арга зүйч, ахлах архивч, ахлах архивч-операторч, хадгалалт хамгаалалтын технологич</p> <p>3.Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн шинжээч</p> <p>4.Сорьц тогтоох лабораторийн химич-шинжээч, хэмжил зүйн техникч,</p> <p>5.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дээж хүлээн авагч эмч, судлагч</p> <p>6.Цаг уур, орчны шинжилгээний газрын мэргэжилтэн</p> <p>7.Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн байгаль орчны шинжээч, мэргэжилтэн</p> <p>8.Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн ахлах инженер, мэргэжилтэн</p> <p>9.Нислэгийн цаг уурын төвийн инженер, мэргэжилтэн 10.Нийслэлийн лабораторийн шинжээч, дээж хүлээн авагч</p>	

7.	ТҮМ-4		<p>1.Төрийн архивын микрофильмийн техникч, микрофиш, фильмийн хальс боловсруулагч, сан хөмрөгч, уншлагын танхимын эрхлэгч, архивч-операторч, архивч-эх бэлтгэгч</p> <p>2.Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын архив, бичиг хэргийн эрхлэгч</p> <p>3.Төрөлжсөн болон тусгай архивын зааварлагч-арга зүйч, архивч, сэлбэн засагч, архивч-операторч</p> <p>4.Сорьц тогтоох лабораторийн сорьц дарагч, үнэт металл хайлагч</p> <p>5.Аймаг, орон нутгийн лабораторийн шинжээч, дээж авагч, их эмч, судлагч, 6.Аймаг, хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн инженер, мэргэжилтэн, байгаль орчны шинжээч, газгенераторч, цаг уурын ажиглагч</p>	
8.	ТҮМ-3		<p>1.Төрийн архивын дэвтэрлэгч, хэвлэгч, химич-лаборант, галын болон хамгаалалтын системийн техникч, баримт ариутгагч 2.Яам, агентлаг, аймаг, нийслэлийн ЗДТГ-аас бусад байгууллагын архив, бичиг хэргийн эрхлэгч, архивч</p>	
9.	ТҮМ-2		1.Лабораторийн автоклавчин	
10.	ТҮМ-1		1.Лабораторийн шил угаагч, ариутгагч	